

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 5-р цэцэрлэгийн  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/139/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi@audit.gov.mn](http://www.dornogovi@audit.gov.mn)

Дорноговь аймаг  
Сайншанд сум  
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734  
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр  
Утас:70523020  
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа  
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (705) 2-27-34

Цэвэр хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2023.02.24 № 1-6/195

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

САЙНШАНД СУМЫН ХҮҮХДИЙН  
5-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
М. МӨНГӨНСАРАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 5-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын хүүхдийн 5-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Илрүүлэлтээр эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулсан ч Сангийн Сайдын баталсан маягтын дагуу бараа материалын орлого, зарлага, эхний болон эцсийн үлдэгдлийн тоо ширхэг, хэмжээг тодорхой гаргаагүй байна. Энэ нь УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын

01000400

үсэг зурах", "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 377.5 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 279.6 сая төгрөгийн 17 гүйлгээ, 4.8 сая төгрөгийн 2 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 49.0 төгрөгийн орлогын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 5.3 сая төгрөгийн 2 шийдвэрийн мэдээлэл огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2021 оны 9-12 сарын ур чадварын нэмэгдлийг 2022 оны 1 сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар 2022 онд олгож, тайлант хугацааны зардлаар бүртгэсэн, мөн байгууллагын оны тэргүүн болсон 3 ажилтанд үндсэн цалингийн 60-80 хувиар шагнал олгосон ба "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын заалтад шагнал олгох дүн, хувийг тодорхой тусгаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.4 дэх заалт "Төрийн албан хаагчийг үнэ бүхий зүйлээр шагнах тэмдэглэлт үйл явдлыг тухайн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгаж мөрдөнө." гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 15 зорилт, 34 арга хэмжээний хэрэгжилт 84.1 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.7 хувийн биелэлттэй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>66,701,683.52</b>	<b>99,855,289.99</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	26,279,117.27
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	26,279,117.27
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	26,279,117.27
31211	Төрийн сангийн харилцах	-	26,279,117.27
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	53,146.80	53,146.80
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	53,146.80	53,146.80
3351	Байгууллагаас авах авлага	53,146.80	53,146.80
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	66,648,536.72	73,523,025.92
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	10,206,821.92	10,187,911.92
35110	Тусгай зориулалттай материал	10,047,121.92	10,127,711.92
35130	Эм боох материал	159,700.00	60,200.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	56,441,714.80	63,335,114.00
35410	Бичиг хэргийн материал	673,080.00	932,779.00
35420	Аж ахуйн материал	49,216,554.00	52,745,289.00
35440	Түлш, шатах тослох материал	220,000.00	130,000.00
35450	Барилгын засварын материал	100,000.00	100,000.00
35460	Хүнсний материал	4,177,940.80	7,372,906.00
35470	Бусад хангамжийн материал	2,054,140.00	2,054,140.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,135,353,882.61</b>	<b>1,098,169,690.20</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,135,353,882.61	1,098,169,690.20
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,052,252,549.21	1,015,156,356.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,026,558,576.65	1,026,558,576.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,176,124.19)	(76,221,277.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	79,328,569.00	80,700,909.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,012,473.83)	(40,264,811.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,872,041.36	39,686,041.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,138,187.88)	(16,800,176.31)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,970,093.29	2,970,093.29
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,672,897.19)	(2,822,075.07)
39217	Ном	1,522,952.00	1,349,077.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	83,101,333.40	83,013,333.44
39301	Програм хангамж	352,000.00	352,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(146,666.60)	(234,666.56)
39303	Бусад биет бус хөрөнгө	82,896,000.00	82,896,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,202,055,566.13</b>	<b>1,198,024,980.19</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,202,055,566.13</b>	<b>1,198,024,980.19</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,202,055,566.13	1,198,024,980.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	221,678,458.50	221,678,458.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	898,046,273.39	918,832,722.84
51210	Өмнөх үеийн үр дүн	898,046,273.39	932,378,133.78
51220	Тайлант үеийн үр дүн	-	(13,545,410.94)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	82,330,834.24	57,513,798.85
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,202,055,566.13</b>	<b>1,198,024,980.19</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>366,673,838.83</b>	<b>417,555,751.35</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>366,673,838.83</b>	<b>417,555,751.35</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	332,968,400.00	356,102,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	356,102,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,968,400.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	544,580.00	313,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	172,000.00	103,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	372,580.00	210,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	33,160,858.83	61,139,951.35
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,160,858.83	61,139,951.35
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>381,348,845.39</b>	<b>430,921,287.29</b>

21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,348,845.39	430,921,287.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	363,872,872.56	425,320,708.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	246,914,376.17	266,369,510.59
210101	Үндсэн цалин	144,912,127.37	212,044,588.59
210102	Нэмэгдэл	73,719,902.80	44,684,969.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,700,000.00	-
210104	Урамшуулал	20,582,346.00	9,639,953.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,253,446.00	32,707,118.14
210201	Тэтгэврийн даатгал	22,087,873.97	22,101,763.49
210202	Тэтгэмжийн даатгал	2,415,517.85	2,651,338.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,727,218.65	2,121,070.54
210204	Ажилгүйдлийн даатгал	456,621.41	530,267.73
210205	Эрүүл мэндийн даатгал	4,566,214.12	5,302,677.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,760,858.83	42,549,107.46
210301	Гэрэл, цахилгаан	295,554.68	6,463,643.46
210302	Түлш, халаалт	28,997,496.15	29,846,960.00
210303	Цэвэр, бохир ус	3,467,808.00	6,238,504.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,366,121.20	1,942,787.20
210401	Бичиг хэрэг	249,100.00	821,000.00
210402	Тээвэр, шатахуун	190,000.00	90,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	429,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,048,021.20	1,030,907.20
2105	Нормативт зардал	9,409,671.20	32,703,287.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	222,100.00	99,500.00
210502	Хоол, хүнс	9,187,571.20	32,603,787.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	605,000.00	804,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	605,000.00	24,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	779,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,563,399.16	48,244,397.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,588,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,707,800.00	11,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,855,599.16	41,645,217.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,475,972.83	5,600,578.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	227,100.00	5,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	227,100.00	5,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	578.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	578.89
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,248,872.83	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,248,872.83	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(14,675,006.56)	(13,365,535.94)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,004,753.78	179,875.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,004,753.78	179,875.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,004,753.78)	(179,875.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(15,679,760.34)	(13,545,410.94)

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	366,673,838.83	427,055,576.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	8,499,825.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	8,499,825.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,499,825.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	8,499,825.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	366,673,838.83	418,555,751.35
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	332,968,400.00	356,205,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	356,205,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,968,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	544,580.00	1,210,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	172,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	372,580.00	1,210,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,160,858.83	61,139,951.35

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,160,858.83	61,139,951.35
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>344,202,938.83</b>	<b>396,150,559.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>344,202,938.83</b>	<b>396,150,559.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>326,726,966.00</b>	<b>390,549,980.19</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	239,398,475.17	265,970,493.88
210101	Үндсэн цалин	134,459,855.37	210,508,693.21
210102	Нэмэгдэл	75,088,273.80	46,152,146.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,340,000.00	-
210104	Урамшуулал	21,510,346.00	9,309,653.99
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,253,446.00	32,959,644.85
210201	Тэтгэврийн даатгал	21,191,500.84	22,665,014.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,515,411.29	2,651,338.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,012,349.06	2,121,070.54
210204	Ажилгүйдлийн даатгал	503,262.23	530,267.73
210205	Эрүүл мэндийн даатгал	5,030,922.58	4,991,953.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,760,858.83	42,549,107.46
210301	Гэрэл, цахилгаан	295,554.68	6,463,643.60
210302	Түлш, халаалт	28,997,496.15	29,846,960.00
210303	Цэвэр, бохир ус	3,467,808.00	6,238,504.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,095,600.00	-
210401	Бичиг хэрэг	389,650.00	-
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	429,000.00	-
210404	Ном, хэвлэл	6,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	966,142.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,004,808.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,910,406.00	36,208,390.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	362,500.00	-
210502	Хоол, хүнс	11,772,906.00	36,208,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,775,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,580.00	699,330.00
210604	Урсгал засвар	500,580.00	699,330.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,315,000.00	804,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,099,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	804,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,492,600.00	11,358,514.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,308,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,492,600.00	2,049,914.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,475,972.83</b>	<b>5,600,578.89</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	227,100.00	5,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	227,100.00	5,600,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	578.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	578.89
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	17,248,872.83	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,248,872.83	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>22,470,900.00</b>	<b>30,905,017.27</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>22,304,900.00</b>	<b>4,625,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>22,304,900.00</b>	<b>4,625,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	22,304,900.00	4,625,900.00
222001	Тоног төхөөрөмж	22,170,000.00	4,619,900.00
223001	Бусад хөрөнгө	134,900.00	6,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(22,304,900.00)</b>	<b>(4,625,900.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	166,000.00	26,279,117.27
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	26,279,117.27

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>221,678,458.50</b>	<b>82,330,834.24</b>	<b>898,046,273.39</b>	1,202,055,566.13
D01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>221,678,458.50</b>	<b>82,330,834.24</b>	<b>898,046,273.39</b>	1,202,055,566.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	34,331,860.39	34,331,860.39
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>221,678,458.50</b>	<b>82,330,834.24</b>	<b>932,378,133.78</b>	1,236,387,426.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(24,817,035.39)	-	(24,817,035.39)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(13,545,410.94)	(13,545,410.94)
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>221,678,458.50</b>	<b>57,513,798.85</b>	<b>918,832,722.84</b>	1,198,024,980.19

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	418,986,800.00	400,776,459.08	18,210,340.92
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	418,986,800.00	396,276,459.08	22,710,340.92
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	418,986,800.00	390,675,880.19	28,310,919.81
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	284,365,800.00	265,970,493.88	18,395,306.12
210101	Үндсэн цалин	239,179,100.00	210,508,693.21	28,670,406.79
210102	Нэмэгдэл	41,832,700.00	46,152,146.68	(4,319,446.68)
210104	Урамшуулал	3,354,000.00	9,309,653.99	(5,955,653.99)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,256,300.00	32,959,644.85	2,296,655.15
210201	Тэтгэврийн даатгал	23,974,100.00	22,665,014.76	1,309,085.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,789,100.00	2,651,338.27	137,761.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,288,300.00	2,121,070.54	167,229.46
210204	Ажилгүйдлийн даатгал	564,100.00	530,267.73	33,832.27
210205	Эрүүл мэндийн даатгал	5,640,700.00	4,991,953.55	648,746.45
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,964,600.00	42,549,107.46	415,492.54
210301	Гэрэл, цахилгаан	5,398,700.00	6,463,643.46	(1,064,943.46)
210302	Түлш, халаалт	32,410,500.00	29,846,960.00	2,563,540.00
210303	Цэвэр, бохир ус	5,155,400.00	6,238,504.00	(1,083,104.00)
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	39,661,600.00	36,208,390.00	3,453,210.00
210502	Хоол, хүнс	39,661,600.00	36,208,390.00	3,453,210.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	700,000.00	699,330.00	670.00
210604	Урсгал засвар	700,000.00	699,330.00	670.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	814,000.00	804,500.00	9,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	804,500.00	9,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,224,500.00	11,484,414.00	3,740,086.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,974,500.00	9,434,500.00	540,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,250,000.00	2,049,914.00	3,200,086.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	5,600,578.89	(5,600,578.89)
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	5,600,578.89	(5,600,578.89)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,600,000.00	(5,600,000.00)
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	578.89	(578.89)
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>4,500,000.00</b>	(4,500,000.00)
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	4,500,000.00	(4,500,000.00)
222001	Тоног төхөөрөмж	-	4,500,000.00	(4,500,000.00)
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	418,986,800.00	427,055,576.35	(8,068,776.35)
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	357,431,100.00	356,205,800.00	1,225,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	357,431,100.00	356,205,800.00	1,225,300.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	61,555,700.00	61,139,951.35	415,748.65
132001	Орон нутгийн төсвөөс	61,555,700.00	61,139,951.35	415,748.65
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	9,709,825.00	(9,709,825.00)
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	9,709,825.00	(9,709,825.00)
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>26,279,117.27</b>	(26,279,117.27)
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	20.00	20.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,210,000.00
213305	Нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл шилжүүлэг	-	1,210,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	1,210,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,210,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,210,000.00

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 51.0 сая төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 51.0 сая төгрөгийн 6 алдааг залрууллаа.

### Залруулсан алдаа:

1. Дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 24.7 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг;
2. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүн 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг;
3. Харилцагч 7 байгууллагаас 8.5 сая төгрөгийн анхан шатны цахим төлбөрийн баримт аваагүй байсныг;
4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлт санхүүжилтийн тайлан алдаатай байсныг;
5. Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8.5 сая төгрөгийг алдаатай бүртгэсэн, ахмадын санд шилжүүлсэн 8.1 сая төгрөгийн ажил гүйлгээг орлого үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэснийг;
6. Авлага цуглуулалт 1.0 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж, өмнөх онд илэрсэн зөрчлийг давтан гаргасан тул 1 хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 80 хувиар буюу 0.9 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

### 3.2 Хариуцлага тооцуулах албан шаардлага

#### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 377.5 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 279.6 сая төгрөгийн 17 гүйлгээ, 4.8 сая төгрөгийн 2 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 49.0 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 5.3 сая төгрөгийн 2 шийдвэрийн мэдээлэл огт мэдээлээгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй байна.

### **3.3 Зөвлөмж**

#### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулсан ч Сангийн Сайдын баталсан маягтаар тайланг тоо ширхэгээр гаргаагүй байна.

Энэ нь УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч сар бүр эд хариуцагчийн тайланг хянан, тоо ширхэгийг тодорхой гаргаж, гарын үсэг болон бусад баталгаажуулалтыг ханган хариуцлагатай ажиллах.

#### **2. Дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2021 оны 9-12 сарын ур чадварын нэмэгдлийг 2022 оны 1 сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар 2022 онд олгож, тайлант хугацааны зардлаар бүртгэсэн ба энэ нь Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 5 дахь заалт “Ур чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно.”-ыг зөрчсөн байна. Мөн байгууллагын оны тэргүүн болсон 3 ажилтанд “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.12 заалтыг үндэслэн үндсэн цалингийн 60-80 хувиар урамшуулал олгосон ба уг заалтад урамшуулал олгох дүн, хувийг тодорхой тусгаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.4 дэх заалт “Төрийн албан хаагчийг үнэ бүхий зүйлээр шагнах тэмдэглэлт үйл явдлыг тухайн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд тусгаж мөрдөнө.” гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дахин үнэлгээний нэмэгдлийн дүн 24.7 сая төгрөгөөр зөрүүтэй байсан	1	24,717.1	0	-	1	24,717.1	1	24,717.1	0	-		
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүн 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй байсан	1	200.6	0	-	1	200.6	1	200.6	0	-		
Харилцагч 7 байгууллагаас 8.5 сая төгрөгийн анхан шатны цахим төлбөрийн баримт аваагүй байсан	1	8,499.8	0	-	1	8,499.8	1	8,499.8	0	-		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлт санхүүжилтийн тайлан алдаатай байсан	1	-	0	-	1	-	1	-	0	-		
Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8.5 сая төгрөгийг алдаатай бүртгэсэн, ахмадын санд шилжүүлсэн 8.1 сая төгрөгийн ажил гүйлгээг орлого үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэсэн	1	16,549.8	0	-	1	16,549.8	1	16,549.8	0	-		
Авлага цуглуулалт 1.0 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн	1	1,000.0	0	-	1	1,000.0	1	1,000.0	0	-		
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>50,967.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>50,967.3</b>	<b>6</b>	<b>50,967.3</b>	<b>-</b>	<b>-</b>		

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулсан ч Сангийн Сайдын баталсан маягтаар тайланг тоо ширхэгээр гаргаагүй байна.	1						1	-				
2021 оны 9-12 сарын ур чадварын нэмэгдлийг 2022 оны 1 сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар 2022 онд	1						1	-				

олгож, тайлант хугацааны зардлаар бүртгэсэн ба энэ нь Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 5 дахь заалт "Ур чадварын нэмэгдлийг тухайн байгууллага жил бүрийнхээ төсөвт тусгаж олгоно."-ыг зөрчсөн байна. Мөн байгууллагын оны тэргүүн болсон 3 ажилтанд "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 3.12 заалтыг үндэслэн үндсэн цалингийн 60-80 хувиар урамшуулал олгосон ба уг заалтад урамшуулал олгох дүн, хувийг тодорхой тусгаагүй байна.											
Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 80 хувиар буюу 0.9 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	946.0	1	946.0							
Дүн	3	946.0	1	946.0		2					-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>							
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 377.5 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 279.6 сая төгрөгийн 17 гүйлгээ, 4.8 сая төгрөгийн 2 шийдвэрийг хугацаа хоцроосон. Мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 49.0 сая төгрөгийн орлогын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 5.3 сая төгрөгийн 2 шийдвэрийн мэдээлэл огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>		

